COVID-19 өвчний үеийн ялгаварлан гадуурхалтыг сэтгэл түгшилт болон сэтгэл гутралын байдалтай харьцуулан судлах

Б.Баттуяа[1,2], З.Хишигсүрэн[1], Д.Оюунсүрэн[1]

[1]АШУҮИС, АУС, Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим
[2]ХӨСҮТ
Цахим шуудан: battuya26@gmail.com, Утас: 90080845

Түлхүүр үг:

Ялгаварлан гадуурхалт
Шинэ коронавирус
Нэр хоч өгөх
Эмчлүүлэгч

Товч утга:

Үндэслэл: Хувь хүнийг өвчилсөн өвчнөөр нь бусдаас гадуурхан, иргэний эрхийг хязгаарлах, хасахыг өвчнөөр нь ялгаварлан гадуурхах үзэл хэмээн нэрлэх бөгөөд дэлхий дахинаа COVID-19 цар тахал эхэлснээс хойш хүн амын дунд уг өвчнөөр өвдсөн иргэдийг ялгаварлан гадуурхах нь олон хэлбэрээр илэрч байна. Бид COVID-19 өвчнөөр өвдсөн иргэдийн сэтгэл түгшилт болон ялгаварлан гадуурхалтанд өртсөн байдлыг судлан тогтоохыг зорьсон юм. **Арга, аргачлал**: Судалгааг тойм судалгааны агшингийн загвараар онлайн асуумж судалгааны аргыг ашиглан зохион байгуулав. **Үр дүн**: Шинээр COVID-19 өвчтэй болох нь батлагдсан 18-85 насны, нийт 265 эмчлүүлэгч бөглөсөн бөгөөд 67.2% (n=178) нь эмэгтэй, 71.3% нь дээд боловсролтой, өрхийн дундаж орлого 1000000-2000000 төгрөг байв. Судалгаанд оролцогсодын 62.26%-д нь сэтгэл түгшилт; 66.42%-д (n=176) нь сэтгэл гутрал илэрч байв. Эмэгтэй хүйсийн оролцогчдод сэтгэл гутрал (p=0.005) болон сэтгэл түгшилтийн (p=0.001) түвшин илүү байсан. Нийт оролцогчийн 98% нь ялгаварлан гадуурхалд өртсөн байсан ба тэдний 36%-д нь өөрийн гадуурхалтын түвшин дунд зэрэг, 61.9%-д нь өөрийн гадуурхалтын түвшин өндөр байсан. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд илүү өөрийгөө ялгаварлан гадуурхах байдалтай тодорхойлогдсон нь статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай (x^2=8.172; p=0.017) байсан бол нийгмийн (x^2=2.74; p=0.254) ялгаварлан гадуурхалтанд өртсөн байдал нь хүйсийн хувьд ялгаагүй байв. Сэтгэл түгшилтийн илрэлийг нийгмийн (x^2=19.47; p=0.003) ба өөрийн (x^2=37.27; p=0.001) ялгаварлан гадуурхалтанд өртсөн байдлын түвшингээр харьцуулахад, статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. **Дүгнэлт**: COVID-19 өвчнөөр өвчлөгсөд нийгмийн болон өөрийн ялгаварлан гадуурхалтанд 98% өртсөн бөгөөд сэтгэл түгшилтийн илрэлийн түвшингээс хамааран нийгмийн (p=0.003) ба өөрийн (p=0.001) ялгаварлан гадуурхалтанд өртсөн байдал ач холбогдол бүхий ялгаатай тодорхойлогдсон боловч сэтгэл гутралын илрэлээс ялгаварлан гадуурхалтын хэлбэрүүд статистик ач холбогдол бүхий ялгаагүй илэрч байв.

Үндэслэл: Хувь хүнийг өвчилсөн өвчнөөр нь бусдаас гадуурхан, иргэний эрхийг хязгаарлах, хасахыг өвчнөөр нь ялгаварлан гадуурхах үзэл хэмээн нэрлэх[1] бөгөөд дэлхий дахинаа цар тахал болоод буй COVID-19 халдварт өвчний дэлдэлттэй холбоотой хүн амын дунд уг өвчнөөр өвдсөн иргэдийг ялгаварлан гадуурхал нь олон хэлбэрээр илэрч байна. Бангладеш улсын судлаачдын урьдчилан таамагласанаар COVID-19-ын хөл хорионоос үүдэлтэйгээр цуурхал, худал хуурмаг мэдээлэл, шинжлэх ухааны бус мэдээлэл тархах, засаглалын хязгаарлалт нэмэгдэн олон нийтийн үймээн самуун, стресс, ялгаварлан гадуурхах байдал нэмэгдэж байгаа юм[2]. Эрүүл мэндийн салбар дахь нийгмийн ялгаварлан гадуурхалт гэдэг нь өвөрмөц тодорхой ямар

нэгэн өвчинд нэрвэгдсэн хүн эсвэл хэсэг бүлэг хүмүүс рүү чиглэсэн сөрөг хандлагыг хэлнэ. Тухайлбал, корона вируст халдвартай хүмүүст нэр хоч өгөх, халдварын тухай хэвшмэл буруу ойлголт, нийгмээс тусгаарлан эмчлэх, эсвэл уг халдвартай холбоотой гэж үзсэний улмаас нийгэмд эзлэх байр суурийг алдагдуулан, ялгаварлан гадуурхах гэсэн үг юм[3]. Эрүүл мэндийн тусламжийн хүрээн дэх ялгаварлан гадуурхалт, ад шоо үзэх зэрэг нь эрүүл мэндийн тусламжийн үр дүнд сөргөөр нөлөөлж, өвчин эмгэгийг цаг тухайд нь оношлох, зохих эмчилгээ хийлгэхэд саад болохоос гадна сэтгэлийн түгшүүр, сэтгэл гутрал зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг нэмэгдүүлэх нөлөөлөл үзүүлдэг билээ[4]. Хэрэв ялгаварлан гадуурхалтыг бууруулахгүй буюу зогсоохгүй бол өвчтөн өвчнөө нуух, эмчилгээнээс татгалзах, нийгэмд халдвар тараах зэрэг хор уршигтай юм[5].


Зорилго: COVID-19 өвчний улмаас эмчлүүлэгсдийн эсрэг нийгмийн ялгаварлан гадуурхалтын байдлыг үнэлэн, сэтгэл гутрал болон сэтгэл түгшилтийн байдалтай харьцуулан судлахад оршино.

Зорилт: COVID-19 өвчний улмаас эмчилгээ хийлгэж байгаа иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн дэмжлэг тусламжийн хэрэгцээг тодорхойлох.

Арга, аргачлал: Судалгааг тойм судалгааны агшингийн загвараар асуумж судалгааны аргыг ашиглан зохион байгуулав. Судалгааны ёсзүйн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэсэн. Оролцогчдын сэтгэцийн байдлыг (Сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, ялгаварлан гадуурхалт) үнэлэхдээ олон улсын стандарт аргачлалыг ашигласан бөгөөд хариултын итгэгдэх байдлыг Кронбахын коэффициентоор тооцоход нийгмийн ялгаварлан гадуурхалтыг үнэлэх асуумжинд хариулсан байдлын итгэгдэх чанар нь (Cronbach alpha=0.88), өөрийн ялгаварлан гадуурхалтыг үнэлэх асуумжинд хариулсан байдлын итгэгдэх чанар нь (Cronbach alpha=0.89) хангалттай түвшинд байв.

Үр дүн: Асуумжийг шинээр COVID-19 өвчтэй болох нь батлагдсан 18-85 насны 265 эмчлүүлэгчээс авсан бөгөөд хүйсийн хувьд 67.2% (n=178) нь эмэгтэй, 32.8% (n=87) нь эрэгтэй оролцогч байсан. Нийт оролцогчийн 25.7-34.3% нь 25-34, 35-44 насны бүлгийн оролцогч байсан ба боловсролын хувьд нийт оролцогчийн 71.3% (n=189) нь дээд боловсролтой, өрхийн дундаж орлого 1000000-2000000 төгрөг байлаа.

Судалгаанд оролцогсодын 62.26%- д (n=165) нь сэтгэл түгшилт илэрч байсан бол оролцогчдын 66.42%-д (n=176) нь сэтгэл гутрал илэрч байв.



Зураг 1. Ковид-19 өвчний үеийн сэтгэл түгшилтийн байдлыг хүйсээр харуулсан байдал

Зураг 1-ээс харахад, эмэгтэй хүйсийн оролцогчдод сэтгэл түгшилтийн түвшин эрэгтэй хүйсийн оролцогчдоос статистикийн ач холбогдолтой илүү байв (Chi square=144.2; p=0.000). Нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 98% нь ялгаварлан гадуурхалд өртсөн байсан ба тэдгээр хүмүүсийн 36% нь өөрийн гадуурхалтын түвшин дунд зэрэг, 61.9% нь өөрийн гадуурхалтын түвшин өндөртэй байсан.



Зураг 2. Ковид-19 өвчний үеийн сэтгэл гутралын байдлыг хүйсээр харуулсан байдал

Зураг 2-д харуулсанаар, оролцогчдын дунд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү сэтгэл гутралд өртөмтгий байв. Эмэгтэй хүйсийн оролцогчдод сэтгэл гутралын түвшин эрэгтэй оролцогчидтой харьцуулахад статистик ач холбогдол бүхий өндөр байлаа.

Ялгаварлан гадуурхалтын хэлбэрийг хүйсийн байдлаар судлан үзэхэд, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү өөрийгөө ялгаварлан гадуурхах байдалтай тодорхойлогдсон нь статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай (Chi square=8.172; p=0.017) байсан хэдий ч нийгмийн (Chi square=2.74; p=0.254) ялгаварлан гадуурхалтанд өртсөн байдал нь хүйсийн хувьд ялгаа ажиглагдсангүй.

Харин нийгмийн ба өөрийн ялгаварлан гадуурхалтанд өртсөн байдлыг насны бүлэг, гэрлэлтийн байдал, хувь хүний сэтгэцийн хэв шинж, болон сэтгэл гутралын илрэлийн түвшинтэй харьцуулан тодорхойлоход статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй.

Сэтгэл түгшилтийн илрэлийн түвшинг нийгмийн (Chi square=19.47; p=0.003) ба өөрийн (Chi square=37.27; p=0.001) ялгаварлан гадуурхалд өртсөн түвшинтэй харьцуулахад, статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа.

Хэлцэмж: Хүн төрөлхтөн сүүлийн 100 жилд 7 цар тахалтай нүүр тулан даван туулсан байдаг. Цар тахлын дэглэмд удаан хугацаагаар байгаа хэн бүхэнд стресс, түгшүүр, айдас, нойргүйдэл, анхаарал сарних зэрэг шинжүүд илрэхээс гадна нийгмээс ялгаварлан гадуурхагдах байдал тохиолдож байдгийг судлаачид цохон тэмдэглэж байна[5,6,7]. Хамгийн эмзэг нөхцөл бол COVID-19 өвчтэй хүмүүс нь шинээр гарч буй цуу ярианд өртөмтгий, янз бүрийн хэлбэрийн гадуурхал, тухайлбал, “Байгууллагын гадуурхал”, “Хамт олны гадуурхал”, “Орон байрны гадуурхал” ба “Үл хайхрах гадуурхал” зэрэгт өртсөнөөр нийгмийн зай барилт, нийгмээс тусгаарлагдах, нийгэмд гадуурхагдах явдлыг улам бүр гүнзгийрүүлж байгаа юм. Нийгмийн гадуурхалтын эдгээр олон талт хэлбэрүүдийн хувьд олон нийтийн дунд сэтгэлийн хөөрөгдлийг бий болгож, нийгмийн эсэн мэнд байдлыг хямраан тогтворгүйтүүлдэг байна. Товчхондоо нийгмийн гадуурхалын энэхүү хэвийн бус үзэгдэл нь нийгмийн бүх харилцаанд сөргөөр нөлөөлж COVID-19 өвчинд нэрвэгдсэн хувь хүнийг “өөрийгөө ялгаварлан гадуурхан, дорд үздэг” нэгэн болгон хувиргаж нийгэм хамтын ажиллагаагүйгээр оршин тогтноход хүргэж байна хэмээн судлаачид цохон тэмдэглэжээ[8,9].

Ялгаварлан гадуурхах, хавчин гадуурхах, үзэн ядах гэсэн нийгмийн гадуурхалт нь нийгэмд хүчтэй тархаж байна, яагаад гэвэл вирусыг хэн тээж яваа, хэн нь биш гэдгийг тодорхойлоход хэцүү байдаг. COVID-19 өвчний тохиолдол болон нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны явцад илрүүлсэн бусад халдвар авсан хүмүүсийг ойр дотны хүмүүсийнх нь хамт буруутгаж, “гэмт хэрэгтнүүдтэй” харьцуулж байна[10,11,12].

Бидний судалгааны дүнгээс харахад, нийт оролцогчийн 62.26%-д нь сэтгэл түгшилтийн багаас хүнд зэргийн түвшинд тодорхойлогдсон бөгөөд 98% нь ялгаварлан гадуурхалтанд өртсөн байгаа тул цаашид хүн амын дунд халдварт өвчний үеийн сэтгэл зүйн тусламж үйлчилгээ нэн шаардлагатай байгааг харуулж байна.

Дүгнэлт: COVID-19 өвчнөөр өвчлөгсөд нийгмийн болон өөрийн ялгаварлан гадуурхалтанд 98% өртсөн бөгөөд сэтгэл түгшилтийн илрэлийн түвшингээс хамааран нийгмийн (p=0.003) ба өөрийн (p=0.001) ялгаварлан гадуурхалтанд өртсөн байдал ач холбогдол бүхий ялгаатай тодорхойлогдсон боловч сэтгэл гутралын илрэлээс ялгаварлан гадуурхалтын хэлбэрүүд статистик ач холбогдол бүхий ялгаагүй илэрч байгаа нь Япон болон Европын зарим судлаачдын хийсэн судалгааны үр дүнтэй ойролцоо байлаа.

Ном зүй:

1. *С.Бямбасүрэн “Сэтгэцийн эмгэг судлал”, Улаанбаатар 2019 он, х 384*
2. *Hasan, M. T., Hossain, S., Saran, T.R., Ahmed, H. U. (2020). Addressing the COVID-19 related stigma and discrimination: A fight against infodemic in Bangladesh. File:///C:/users/HP/downloads/*

Preprint_COVID19 related stigma and discrimination_MTH.Pdf

3. *IFRC, U., WHO. (2020). Social Stigma associated with COVID-19. A guide to preventing and addressing social stigma. 2020 оны 8 сар*
4. *Saeed, F., R. Mihan, S. Z. Mousavi, R. L. Reniers, F. S. Bateni, R. Alikhani and S. B. Mousavi (2020). "A Narrative Review of Stigma Related to Infectious Disease Outbreaks: What Can Be Learned in the Face of the Covid-19 Pandemic?" Front Psychiatry 11: 565919.*
5. *З.Хишигсүрэн "Сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн сувилахуй", Улаанбаатар 2016 он, х 68*
6. *Brooks SK, Webster RK, Smith LE, et al. The psychological impact of quarantine and how to reduce it: a rapid review of the evidence. Lancet. 2020;395(10227):912-920. doi:10.1016/S0140-6736(20)30460-8*
7. *Maunder, R., Hunter, J., Vincent, L., Bennett, J., Peladeau, N., Leszcz, M., & Mazzulli, T. The immediate psychological and occupational impact of the 2003 SARS outbreak in a teaching hospital. Canadian Medical Association Journal. 2003;168(10):1245–1251*
8. *Do Duy, C., Nong, V.M., Ngo Van, A., Doan Thu, T., Do Thu, N. and Nguyen Quang, T. COVID-19-related stigma and its association with the mental health of health-care workers after quarantine in Vietnam. Psychiatry Clin. Neurosci.,2020;74:566-568. doi:10.1111/pcn.13120*
9. *Hasan, M. T., Hossain, S., Saran, T.R., Ahmed, H. U. (2020). Addressing the COVID-19 related stigma and discrimination: A fight against infodemic in Bangladesh. File:///C:/users/HP/downloads/Preprint_COVID19 related stigma and discrimination_MTH.Pdf*
10. *Sotgiu, G., & Dobler, C. C. (2020). Social stigma in the time of coronavirus disease 2019. The European respiratory journal, 56(2), 2002461. https://doi.org/10.1183/13993003.02461-2020*
11. *Malecki K, Keating JA, Safdar N. Crisis Communication and Public Perception of COVID-19 Risk in the Era of Social Media [published online ahead of print, 2020 Jun 16]. Clin Infect Dis. 2020;ciaa758. doi:10.1093/cid/ciaa758*
12. *Shigemura J, Ursano RJ, Morganstein JC, Kurosawa M, Benedek DM. Public responses to the novel 2019 coronavirus (2019-nCoV) in Japan: Mental health consequences and target populations. Psychiatry Clin Neurosci. 2020;74(4):281-282. doi:10.1111/pcn.12988*

Comparative study on stigma and anxiety and depression during COVID-19 pandemic

Battuya B[1,2], Khishigsuren Z[1], Oyunsuren D[1]

[1]Department of Mental Health, School of Medicine, MNUMS
[2]National Center of Communicable Diseases
E-mail: battuya26@gmail.com, Tel: 90080845

Background: Stigma is when someone discriminates against a person by his/her illness and restricts or excludes his/her civil rights. Since becoming the pandemic around the world, stigma against people infected with the COVID-19 disease is taking many forms. We aimed to detect the anxiety and discrimination of infected people with COVID-19 disease.
Materials and Methods: The study was conducted using a descriptive cross-actional design and a semi-structured online questionnaire.
Results: Totally 265 patients aged 18-85, who were newly diagnosed with COVID-19 disease, were completed the survey questionnaire. 67.2% (n=178) were female, 71.3% had higher educated, and the average household income was 1.000.000-2.000.000 MNT. Anxiety (62.26%) and depression (66.42%) of the respondents were more assessed in female with higher levels than males ($p \leq 0.005$). Of the total respondents, 98% were discriminated against, 36% of those had a moderate, and 61.9% had a high level of self-stigma. There was a statistically significant difference ($x^2=8.172$; $p= 0.017$) in which men were more likely to self-stigma than in women, and but there was no difference in gender for social-stigma ($p= 0.254$). The level of anxiety was statistically significant compared to the level of social ($x^2=19.47$; $p=0.003$) and self-stigma ($x^2=37.27$; $p=0.001$). But social & self-stigma no differences with statistically significant to comparing age-group, marital status, personality types and depression level.
Conclusion: 98% of people with COVID-19 had social and self-stigma. However the anxiety level was significantly different with the level of social ($p=0.003$) and self-stigma ($p=0.001$), but stigmatization types no significantly differences for depression level.

Keywords: Discrimination, new coronavirus, stigmatization, patient